

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 04-р сарын 28-ны өдөр

Дугаар:23/02

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2023.04.28-ны өдрийн 14.00 цагт эхлэв.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга О.Шинэхүүг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Шинэхүүгийн танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 32,714.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 24.18 % болж, Компанийн тухай хуулийн 69.4-д “Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор энэ хуулийн 69.3-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг хангаж байна.

Хуралд Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат, Г.Алтансүх, С.Пүрэвжав, Б.Батсайхан ,Б.Сумьяа, С.Мягмарсүрэн нарын 9 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө, 2023 оны удирдлагын зардлыг батлах
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Монгол улсын Гавьяат барилгачин, Зөвлөх инженер, “Хүрд” компанийн ерөнхий захирал, томоохон хувьцаа эзэмшигч Бүлтэнхүүгийн Энхжаргал 2023 оны 02-р сарын 03-ны өдөр хүнд өвчний улмаас таалал төгсөж, бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолдсон харамсалтай мэдээг та бүхэнд дуулгаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Үндэсний шуудан /, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04-р сарын 14-ний өдөр хуралдахаар зарлагдсан боловч хурлын ирц 24% болж Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг хангаагүй тул хурлыг хойшлуулж, дахин зарлаад өнөөдөр хуралдаж байна.

Өнөөдрийн хойшлогдсон хуралд **32714** ширхэг хувьцаа эзэмшдэг **9** хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь **24.18** % болж, Компанийн тухай хуулийн 69.4-д “Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор энэ хуулийн 69.3-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг хангаж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулж байна.

Компанийн 2022 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлээ.

Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоотой та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч намтрыг тараасан. Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Хөрөнгөө дахин үнэлүүлэх хэрэгтэй байна. Тайланд 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй гэж байна. Нягтлан бодох бүртгэлийн хуульд зааснаар хөрөнгийг өнөөдрийн түвшинд дахин үнэлгээ хийлгэх ёстой.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Манай компанийн барилгууд 1950-1960 оны барилгууд, засвар хийхэд хүндрэлтэй байдаг. Засвар хийлгэсэн хэмжээндээ дахин үнэлүүлээд байх нь зохимжгүй байдаг. Харин капитал засвар хийсэн, ашиглалт сайжруулж буй хэмжээнд татварын газраас шаардсан хэмжээнд үнэлгээ хийлгэж байгаа. Жишээ нь : Ашиглалтгүй байсан складыг спорт заал болгоход дахин үнэлгээ хийлгэсэн. Ашиглалтгүй хуучирсан склад, цехүүдэд үнэлгээ хийлгэх нь ач холбогдол багатай юм.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Эздийн өмчийн хувьд дахин үнэлгээ хийлгэх нь зөв. Мөнгөн хөрөнгийг банк, банк бусад хадгалуулах, хөрөнгө оруулалт хийх талаар ямар арга хэмжээ авах вэ? Барилга угсралтын ажлын ашгийн хувь 17хувь гэдэг бага харагдаж байна. Гэтэл хувийн компаниуд яагаад ийм бага ашгийн төлөө тендерт ороод байна.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Энэ жилийн хувьд мөнгөн хөрөнгөө банкинд хугацаатайгаар хадгалуулаад 746,6 сая төгрөгийн ашиг олсон. Барилга угсралтын ажлын ашиг 1 тэрбум 501 сая төгрөг байгаа. 2022 онд олсон ашиг бол Сэлбэ дэд төвийн 28мВт чадалтай дулааны станц, Баянзүрх 88 айлын орон сууцнаас олсон ашиг гэхдээ Банкны хадгаламжийн хүү 8-9 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 0 хувьтай байсан. 17 хувийн ашиг бол бас багагүй ашиг юм.

Манай компани 1937 оноос үндсэн үйл ажиллагаа болох барилга угсралтын ажил эрхэлж байгаа түүхэн мөн унаган байгууллага.

Дэлхий нийтээр тархсан ковид, үүнээс үүдэлтэй хил гаалийн асуудлаас болж барилгын материалын үнэ огцом өссөн. Иймээс барилга угсралтын ажлын ашиг бага байгаа. Манай компани орон сууц барьж борлуулдаг компаниуд шиг өндөр ашигтай ажиллаж чадахгүй ээ. Тэд барилгын материалын үнийн өсөлт, валютын ханшийн өөрчлөлттэй уялдуулан орон сууцны м2 үнээ нэмэн борлуулдаг. Манай компанийн хувьд тендерт оролцон, улсын төсөвт батлагдсан үнийн дүнтэй барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа болохоор үнэ нэмэх боломжгүй байдаг. Тендер төсвийн тухай хуульд ашигийн хэмжээг 15 хувиар тооцож төсөв зохиох дүрэмтэй. Бидний хэрэгжүүлж байгаа Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга угсралтын ажлын хувьд гэхэд төсөв хөрөнгө нь 2017 онд батлагдсан, барилгын ажилчдын цалин 2021 оны 01-р сарын 1-нээс 2 дахин өссөн байтал энэ төслийн

хувьд хуучин цалингаар тооцогдсон төсөвтэй. Гэвч бид ажилчиддаа шинэ цалингийн тарифаар цалинг нь олгож байгаа. Мөн материалын үнэ огцом өссөн. Нэгэнт гэрээт ажил учир бид хийгээд дуусна. Ийм болохоор барилга угсралтын ажлын ашиг бага байгаа юм.

Бид аль болох ашигтай ажиллах, банк санхүүгийн бүтээгдэхүүн ашиглаж ашиг олох зорилттой ажиллаж байгаа. Тэглээ гээд бүх мөнгөө хадгаламжид хийж үндсэн үйл ажиллагаагаа хумих боломжгүй. Тухайн цаг үеийн мөнгөний зарцуулалтаа бодолцон хугацаат хадгаламжийг ашиглан ашиг олж байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Одоо байгаа компанийн суурин дээр орон сууцны барилга барих төлөвлөгөө ямар шатандаа байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Контор байрлаж байгаа энэ талбай дээр орон сууц барихаар 2017 онд ерөнхий төлөвлөгөөнд батлуулсан. Одоогоор хөрөнгө оруулалтын асуудлыг шийдээгүй байгаа.

-Барилгын материалын үнэ нэмэгдсэн учир одоогоор тендерт оролцоогүй байгаа. Засгийн газрын хэмнэлтийн бодлого гарсантай холбогдуулан 2023 онд шинээр хийх ажлууд бага байгаа. БХБ Яамны хэмжээнд гэхэд бага хэмжээний 9 ажил л шинээр зарлагдаж байх жишээтэй байна.

-Материалын худалдаа эрхэлж, ашиг олох талдаа анхаарч ажиллах

-Бетон эдлэл, Төмөр хийцийн үйлдвэрийг бие даалгах, өргөжүүлэх. материал үйлдвэрлэл дээр гүйцэтгэх удирдлага анхаарч ажиллах.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Өөрийн газар дээр орон сууц барих ашигтай гэж байна. Газраа орон сууц болгоход нэг л удаа ашиг олоод газаргүй болно биз дээ.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат : Нэг удаа орон сууц зараад борлуулахад газаргүй болно. Тиймээс үйлчилгээтэй орон сууц барих нь зөв юм.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Цаашид компанийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, цалин нэмэгдүүлэх, урамшуулал олгох, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хүний нөөцийг бүрдүүлэх бодлого барьж ажиллана.

Төлөөлөн удирдах зөвлөл, Захирлын зөвлөлийн хурал өнгөрсөн онд цөөн хуралдсан. Энэ онд үйл ажиллагааг тогтмолжуулна.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Одоо дараагийн асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцье. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн товч танилцуулга та бүхний өмнө байна. ТУЗ-ийн гишүүдэд шинээр 3 хүн нэр дэвшиж байгаа. Товч танилцуулья.

Бүлтэнхүү Сумьяа-2010 онд МУБИС бага ангийн арга зүйч, 2018 онд ОТИС-ийн нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 2011 оноос Хүрд компанид нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байгаа.

Энхжаргал Ундрах-2002 онд Худалдаа Үйлдвэрийн дээд сургууль. Бизнесийн удирдлага, 2010 онд ШУТИС-сантихникийн инженер мэргэжлээр төгссөн. Англи хэлтэй. Хүрд компанид Бизнес хөгжлийн албаны даргаар ажиллаж байгаа.

Гаалан Амгалан-1987 онд ШУТИС. Дулаан хангамж, агааржуулалтын инженер. 2002 онд ОТИ Сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.Хувиараа ажилладаг.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2022 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2023 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга О.Шинэхүү санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:


1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **32,714.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **32,714.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
3. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **32,714.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
4. 2023 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **32,064.0** ширхэг хувьцаа буюу **98,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **650** ширхэг хувьцаа буюу **2%**
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **32,714.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0%**


ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 15.20 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН
ХУРЛЫН ДАРГА  Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ГАНТУЯА